

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
Т.БАДРАЛ

2018 оны 7 дүгээр  
сарын 28 ны өдөр

БАТЛАВ  
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГА  
С.ЭНХТҮВШИН

Дугаар 20/16

Улаанбаатар хот

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР,  
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1. Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, цагийн байдлыг үнэлэх, хойшлуулшгүй арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх, цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1. Хамтран ажиллах гэрээний хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар, нөгөө талаас Цаг уур, орчны шинжилгээний газар (цаашид "Талууд" гэх) нь Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн хийх ажил, гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх эрх, үүрэг, хариуцлага бусад харилцааг зохицуулахын тулд энэхүү гэрээг дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1. Онцгой байдлын ерөнхий газрын хүлээх үүрэг

3.1.1. Ус, цаг агаарын аюулт, гамшигт үзэгдэл болох тухай шуурхай мэдээг зарлан мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн болон орон нутгийн радио, телевиз, үүрэн холбооны сүлжээгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нэн даруй мэдээлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцох,

3.1.2. Ус, цаг агаарын аюулт, гамшигт үзэгдэл тохиолдсон үед хохирлын үнэлгээ хийх, үзэгдлийн эрч хүчийг тогтооходоо төв, орон нутгийн цаг уурын байгууллагатай хамтран ажиллах,

3.1.3. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд ашиглаж байгаа пуужин, түлшийг хадгалах, хамгаалахад дэмжлэг үзүүлэх,

3.1.4. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах чиглэлийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах,

3.1.5. Албан хаагчдын дунд тэмцээн уралдаан зохион байгуулах, цаг уурын байгууллагын албан хаагчдад “Аврагч” биеийн тамир, техник-спортын хорооны заалыг тогтоосон өдөр, цагийн хуваарийн дагуу үнэ төлбөргүй ашиглуулах,

3.1.6. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд ашиглах автомашиныг шатахуунаар хангах.

### 3.2. Цаг уур, орчны шинжилгээний газрын хүлээх үүрэг

3.2.1. Цаг агаарын, гадаргын усны, хөдөө аж ахуйн цаг уурын урьдчилсан мэдээ, орчны шинжилгээний мэдээ, ажиглалтын мэдээ, хиймэл дагуулын мэдээ, шаардлагатай тохиолдолд аймаг, нийслэлийн цаг уурын олон жилийн судалгаа, мэдээгээр хангах,

3.2.2. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед сансрын зураг, холбогдох мэдээллээр 24 цагийн турш үйлчлэх,

3.2.3. Ус, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах,

3.2.4. Ус, цаг агаар, орчны аюултай, гамшигт үзэгдлийг дамжуулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, зарлах, үнэлгээ хийх тухай мэдээг Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 1, 2, 3, 4, 5 дугаар хавсралтад заасны дагуу хэрэгжүүлэх,

3.2.5. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үеийн пуужин харвалтад хяналт тавьж, хур тунадас нэмэгдүүлсэн тухай мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвд тухай бүр мэдээлэх,

3.2.6. Тухайн жилийн хур тунадасны хэмжээ, цасан бүрхүүлийн онцлогийг харгалзан ой, хээрийн гал түймрийн эрсдэлтэй, хуурайшилт бүхий бүс нутагт цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 4-10 дугаар саруудад, шаардлагатай тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын захиалгаар зохион байгуулна.

## ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХАМТРАН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Талууд гэрээний биелэлтийг жилд нэг удаа дүгнэнэ.

4.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд асуудлыг хамтарсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.3. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргавал хамтарсан ажлын хэсэг 14 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

#### ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн энэхүү гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

5.2. Гэрээний биелэлтэд Талуудын хамтарсан ажлын хэсэг хяналт тавьж ажиллана.

5.3. Талууд хамтран ажиллах гэрээг 2 жилийн хугацаатай байгуулав.

#### ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАЯГ

Хаяг, индекс: УБ Сүхбаатар дүүрэг  
Партизаны гудамж-6  
Утас: 976-11-325726  
Факс: 976-11-324977  
Цахилгаан шуудангийн хаяг: 210644  
И-мэйл: doc@nema.mn

Хаяг, индекс: УБ Чингэлтэй дүүрэг  
Жуулчны гудамж-5  
Утас: 976-11-264152  
Факс: 976-11-326611  
Цахилгаан шуудангийн хаяг: 15160  
И-мэйл: meteoagency@magicnet.mn